

## ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,  
2019 оны 3-р сарын 20-ны байдлаар


2019 оны 3-р сарын 20-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 3.3 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.9 хувиар өссөн байна.

**Махны дундаж үнэ:** 2019 оны 3-р сарын 20-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 8.5 хувь, үхрийн ястай махны үнэ 5.5 хувь, үхрийн цул махны үнэ 2.9 хувиар өссөн бол, ямааны ястай махны үнэ 1.1 хувиар буурсан бол, адууны ястай махны үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 2.4 хувь, үхрийн ястай махны үнэ 1.0 хувь, үхрийн цул махны үнэ 2.6 хувиар өссөн бол ямааны ястай махны үнэ болон адууны ястай махны үнэ өөрчлөлтгүй байна.

2019 оны 3-р сарын 20-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 7949 төгрөг, үхрийн /ястай/ мах 9393 төгрөг, үхрийн цул мах 11382 төгрөг, адууны /ястай/ мах 6745 төгрөг, ямааны /ястай/ мах 5899 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).


**Зураг 1.** Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ, төгрөг



**Гурилын үнэ:** 2019 оны 3-р сарын 20-ны байдлаар гурилын үнэ өмнөх сараас савласан дээд гурилын үнэ 0.1 хувиар буурсан бол 1-р зэргийн гурилын үнэ 0.3 хувиар өссөн, бусад гурилын үнэ өөрчлөлтгүй байна. Өмнөх 7 хоногоос бүх төрлийн гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

**Будаа, элсэн чихрийн дундаж үнэ:** 2019 оны 3-р сарын 20-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сараас 0.9 хувь, өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна. Элсэн чихрийн үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос 0.6 хувиар өссөн байна. (Зураг2).

**Зураг 2.** Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ, төгрөг



**Төмс, хүнсний ногооны дундаж үнэ:** 2019 оны 3-р сарын 20-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 2.7 хувь, луувангийн үнэ 12.2 хувь, байцааны үнэ 10.3 хувь, хүрэн манжингийн үнэ 10.2 хувь, бөөрөнхий сонгины үнэ 5.2 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногоос төмсний үнэ 1.1 хувь, луувангийн үнэ 3.4 хувь, байцааны үнэ 3.4 хувь, хүрэн манжингийн үнэ 1.5 хувь, бөөрөнхий сонгины үнэ 5.6 хувиар өссөн байна.

**Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ:** 2019 оны 3-р сарын 20-ны байдлаар өмнөх сараас элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 0.1 хувиар өссөн бол задгай сүүний үнэ болон савласан /1 литрийн/ сүүний үнэ өөрчлөлтгүй байна. Өмнөх 7 хоногоос задгай сүүний үнэ 5.1 хувиар буурсан бол элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 0.2 хувь, савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.1 хувиар өссөн байна

Цөцгийн тосны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна. Ургамлын тосны үнэ өмнөх сараас 0.1 хувиар буурсан байна. Өмнөх 7 хоногоос ургамлын тосны үнэ өөрчлөлтгүй байлаа. Өндөгний үнэ өмнөх сараас 0.1 хувиар өссөн бол өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна.